



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022.04.19 № 866  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хандивын тайлангийн дүгнэлт

Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Сонгинохайрхан дүүргийн Монгол Ардын намын хорооноос ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Нийслэл дэх Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Нийслэл дэх төрийн аудитын газар Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Сонгинохайрхан дүүргийн Монгол Ардын намын хороонд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт-4000, Монгол Улсын Ерөнхий

аудиторын 2020 оны А/47 тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлтэй нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

### Дүгнэлт

Сонгинохайрхан дүүргийн Монгол Ардын намын хороо нөхөн сонгуулийн жилийн 04 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэж тайлагнаагүй байна.

Сонгинохайрхан дүүргийн Монгол Ардын намын хорооноос ирүүлсэн хандивын тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт: 2 хуудастай.

Хувийг: Сонгинохайрхан дүүргийн Сонгуулийн хороонд.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Нам эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж,  
дүгнэлт гаргах зааврын хавсралт  
**МАЯГТ-1**

Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуульд оролцох нам, эвслэд "ИРГЭН"-ээс  
өгсөн хандивын тайлангийн маягт  
Монгол Ардын Нам /нам, эвслийн нэр/

| Д/д  | Иргэний овог нэр | Хандив өгсөн иргэний мэдээлэл |     |                   | Хандив өгсөн огноо | Хандивын мөнгөн дүн | Хандив хүлээн авсан |            | Тайлбар        |
|--|------------------|-------------------------------|-----|-------------------|--------------------|---------------------|---------------------|------------|----------------|
|  |                  | Регистрийн дугаар             | Нас | Оршин суугаа хаяг |                    |                     | Утасны дугаар       | Банкны нэр |                |
| Нөхөн сонгуулийн жилийн өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон |                  |                               |     |                   |                    |                     |                     |            |                |
| 1  |                  |                               |     |                   |                    |                     |                     |            | Хандив аваагүй |
| 2  |                  |                               |     |                   |                    |                     |                     |            |                |
| Нөхөн сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-нээс 04 дүгээр сарын 08-ний өдөр хүртэл хугацаанд                 |                  |                               |     |                   |                    |                     |                     |            |                |
| 1  |                  |                               |     |                   |                    |                     |                     |            | Хандив аваагүй |
| 2  |                  |                               |     |                   |                    |                     |                     |            |                |

**Санамж:** Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасан иргэн, хуурийн этгээдээс өгсөн хандивт намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зорлулан өгсөн хандивыг хамруулахгүй

Тамга тэмдэгт /тухайн намын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, албан ёсны тамга тэмдгээр баталгаажуулна./



Хянасан Дэд дарга  
албан тушаал

Махвал Цэнд-Аюуш  
овог нэр

*(Handwritten signature)*  
/...  
Марын үсэг

2022.04.10  
огноо

Нам эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж,  
дүгнэлт гаргах зааврын хавсралт  
**МАЯГТ-2**

Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуульд оролцох нам, эвсэлд “ХУУЛИЙН ЭТГЭЭД”-ээс  
өгсөн хандивын тайлангийн маягт  
Монгол Ардын Нам /нам, эвслийн нэр/

| Д/д | Хуулийн<br>этгээдийн нэр   | Хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээлэл |                           |                                  |                              |                                |       | Хандив хүлээн авсан |                  |  | Мөнгө<br>н дүн | Тайлбар |                   |
|-----|--|---|---------------------------|----------------------------------|------------------------------|--------------------------------|-------|---------------------|------------------|--|----------------|---------|-------------------|
|     |  | Регистрийн<br>дугаар                    | Хаяг,<br>утасны<br>дугаар | Үүсгэн<br>байгуулагдсан<br>огноо | Үйл<br>ажиллагааны<br>чиглэл | Хуулийн<br>этгээдийн<br>хэлбэр | Огноо | Банкны<br>нэр       | Дансны<br>дугаар |  |                |         |                   |
|     | Нөхөн сонгуулийн жилийн өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон |   |                           |                                  |                              |                                |       |                     |                  |  |                |         |                   |
| 1   |  |   |                           |                                  |                              |                                |       |                     |                  |  |                |         | Хандив<br>аваагүй |
| 2   |  |   |                           |                                  |                              |                                |       |                     |                  |  |                |         |                   |
|     | Нөхөн сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-нээс 04 дугаар сарын 08-ний өдөр хүртэл хугацаанд                 |   |                           |                                  |                              |                                |       |                     |                  |  |                |         |                   |
| 1   |  |   |                           |                                  |                              |                                |       |                     |                  |  |                |         | Хандив<br>аваагүй |
| 2   |  |   |                           |                                  |                              |                                |       |                     |                  |  |                |         |                   |

Санамж: Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 25.3.6, 25.4.6-д заасан иргэн,  
хуулийн этгээдээс өгсөн хандивт намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан өгсөн хандивыг хамруулахгүй



Хянасан Дэд дарга  
албан тушаал

Махвал Цэнд-Аюуш  
овог нэр

/Тухайн намын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, албан ёсны тамга тэмдгээ баталгаажуулна./

Махвал Цэнд-Аюуш  
Гарын үсэг

2022.04.10  
ОГНОО